



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 103

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 154,047.2 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,795.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээс 363,342.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 31 зорилт, 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 84 арга хэмжээг бүрэн, 26 арга хэмжээг 30-70 хувиар, 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, нийт дүнгээр 86.4 хувиар үнэлсэн байна.

0702900324

Нэг. Аудитын санал дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	400,932.0	406,815.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,795,647.2	1,981,720.0
Нийт хөрөнгийн дүн	2,196,579.1	2,388,535.0
Нийт өр төлбөрийн дүн		0.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,196,579.1	2,388,535.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,196,579.1	2,388,535.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	619,281.4	1,005,377.9
Үйл ажиллагааны зардлын дүн	622,785.4	805,114.6
Үйл ажиллагааны үр дүн	(3,504.0)	200,263.3
Үйл ажиллагааны бус үр дүн	526.0	37,354.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	(4,030.0)	162,909.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,200,609.1	2,196,579.1
Тайлант оны үр дүн	(4,029.9)	191,955.8
Эцсийн үлдэгдэл	2,196,579.0	2,388,534.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	520,790.8	692,930.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	519,826.8	655,134.5
Үйл ажиллагааны ЦМГ	964.0	37,795.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(964.0)	(37,795.5)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0.0	0.0
Урсгал зардал	0.0	0.0
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0.0	0.0
Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	0.0
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОНТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	457,113.1	581,765.0
Урсгал зардал	457,113.1	581,765.0
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	457,113.1	616,166.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	457,113.1	616,166.1
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0.0	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 48.9 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Тайланд үндсэн хөрөнгийг 19.5 сая төгрөгөөр дутуу, бусад хангамжийн материалыг илүү,
- Тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг 0.1 сая төгрөгөөр дутуу,
- Тайлант үеийн үр дүнг 0.5 сая төгрөгөөр илүү,
- Мөнгөн гүйлгээний тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 28.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй 1 зөрчил² нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Данс бүртгэлд нэгээс дээш жилийн насжилттай 59.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлж барагдуулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл
/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	1	19.5	-	-	1	19.5	1	19.5	-	-	-	-
	1	0.2	-	-	1	0.2	1	0.2	-	-	-	-
	1	0.5	-	-	1	0.5	1	0.5	-	-	-	-
	1	28.7	-	-	1	28.7	1	28.7	-	-	-	-
Дүн	4	48.9	-	-	4	48.9	4	48.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуулагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	1	7.3	-	-	1	7.3	-	-
	1	3.8	-	-	1	3.8	-	-
Нийт дүн	2	11.1	-	-	2	11.1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-